**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СБА-2022/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт

2022 он


Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл
Утас: 9988 4842
Цахим хаяг: gereltekhburtgelaudit01@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


**Товчилсон үгийн жагсаалт**......3
**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**......6
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**......6
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**......6
**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**......8
**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**......8
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**......10
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**......11
**3. Аудитын тайлан**......11
**3.1 Ерөнхий зүйл**......11
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**......12
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**......12
**3.4 Материаллаг байдал**......13
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**......13
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**......13
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**......14
**3.8 Аудитын гол асуудал**......15
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**......15
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**......15
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**......15
**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**......15
**4. Аудитын илрүүлэлт**......16
**4.1 Залруулсан алдаа**......16
**4.2 Төлбөрийн акт**......16
**4.3 Албан шаардлага**......16
**4.4 Зөвлөмж**......17

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022. 02. 25 № 92

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.БАТТӨМӨР
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **39,211,097.00** | **43,142,567.54** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **39,211,097.00** | **43,142,567.54** |
| **351** | **Түүхий эд материал** | **1,208,700.00** | **465,000.00** |
| 35130 | Эм боох материал | 1,208,700.00 | 465,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **35,432,397.00** | **40,037,567.54** |
| 35420 | Аж ахуйн материал | 20,832,567.00 | 29,379,230.71 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,406,950.00 | |
| 35460 | Хүнсний материал | 6,150,080.00 | 279,750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,042,800.00 | 10,378,586.83 |
| 35600 | Мал амьтад | 2,570,000.00 | 2,640,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **845,502,266.59** | **772,501,247.33** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **845,502,266.59** | **772,501,247.33** |
| **392** | **Биет хөрөнгө** | **809,450,266.59** | **736,449,247.33** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 826,838,100.00 | 826,838,100.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (88,499,946.48) | (137,988,398.88) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 19,800,000.00 | 19,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (3,575,000.00) | (6,875,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 130,048,433.27 | 131,922,953.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (110,128,731.03) | (114,455,498.41) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 67,814,142.39 | 72,074,342.39 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (55,628,142.39) | (60,360,511.87) |
| 39217 | Ном | 22,781,410.83 | 5,493,260.83 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **36,052,000.00** | **36,052,000.00** |
| 39301 | Програм хангамж | 1,687,789.00 | 1,687,789.00 |
| 39303 | Хасагдуулга | (1,687,789.00) | (1,687,789.00) |
| 39304 | Бусад биет бус хөрөнгө | 36,052,000.00 | 36,052,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **884,713,363.57** | **815,643,814.87** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **884,713,363.57** | **815,643,814.87** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **884,713,363.57** | **815,643,814.87** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | **522,082,593.56** | **522,082,593.56** |
| 51101 | Өмч: - төрийн | 522,082,593.56 | 522,082,593.56 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(45,305,652.63)** | **(114,375,201.33)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (45,305,652.63) | (45,305,652.63) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (69,069,548.70) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | 407,936,422.64 | 407,936,422.64 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **884,713,363.57** | **815,643,814.87** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,306,099,404.00** | **1,204,087,809.54** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **113,730,804.00** | **8,076,459.54** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **113,730,804.00** | **8,076,459.54** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 113,730,804.00 | 7,868,150.54 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 113,730,804.00 | 7,868,150.54 |
| 120009 | Бусад орлого | | 208,309.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,050,442,200.00** | **1,026,885,200.00** |
| 131001 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,050,442,200.00 | 1,026,885,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **6,940,000.00** | **12,595,250.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 8,762,250.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,940,000.00 | 3,833,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **134,986,400.00** | **156,530,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 134,986,400.00 | 156,530,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,226,236,250.53** | **1,255,869,208.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,226,236,250.53** | **1,255,869,208.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,115,864,178.07** | **1,174,368,006.69** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **795,073,724.58** | **818,806,375.13** |
| 210101 | Үндсэн цалин | 533,646,355.38 | 568,954,578.13 |
| 210102 | Нэмэгдэл | 192,231,545.20 | 178,151,175.00 |
| 210104 | Урамшуулал | 69,195,824.00 | 71,700,622.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **101,958,061.96** | **106,884,853.13** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,625,919.48 | 76,456,753.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,380,191.83 | 7,607,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,700,971.68 | 6,085,599.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,659,054.65 | 1,521,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,591,924.32 | 15,214,100.03 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **108,928,746.00** | **131,285,983.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,628,327.00 | 5,252,889.19 |
| 210302 | Түлш, халаалт | 104,180,419.00 | 125,720,094.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 120,000.00 | 313,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,784,248.00** | **11,059,018.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 547,500.00 | 1,067,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,842,450.00 | 2,478,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,085,298.00 | 825,818.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 140,000.00 | 3,163,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 270,000.00 | 494,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,899,000.00 | 3,029,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **15,942,910.00** | **22,609,608.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,083,800.00 | 1,389,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,476,160.00 | 19,958,508.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,382,950.00 | 1,262,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **5,000,000.00** |
| 210601 | Урсгал засвар | | 5,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **371,700.00** | **394,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 371,700.00 | 394,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,536,141.00** | **3,405,900.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,536,141.00 | 2,541,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 864,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **76,268,646.53** | **74,922,269.24** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,814,410.40 | 2,570,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,188,600.00 | 7,179,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 68,265,636.13 | 65,172,869.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **110,372,072.46** | **81,501,201.55** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **15,893,484.00** | **38,300,274.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,299,000.00 | 1,250,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,594,484.00 | 37,050,274.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **94,478,588.46** | **43,200,927.55** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 94,478,588.46 | 43,200,927.55 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **79,863,153.47** | **(51,781,398.70)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **17,288,150.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 17,288,150.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | (17,288,150.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **79,863,153.47** | **(69,069,548.70)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **522,082,593.56** | **407,936,422.64** | **(45,305,652.63)** | **884,713,363.57** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **522,082,593.56** | **407,936,422.64** | **(45,305,652.63)** | 884,713,363.57 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | | (69,069,548.70) | (69,069,548.70) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **522,082,593.56** | **407,936,422.64** | **(114,375,201.33)** | **815,643,814.87** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,192,368,600.00** | **1,196,219,659.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **208,309.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **208,309.00** |
| 120009 | Бусад орлого | - | 208,309.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,192,368,600.00** | **1,196,011,350.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,050,442,200.00 | 1,026,885,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **6,940,000.00** | **12,595,250.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 8,762,250.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,940,000.00 | 3,833,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **134,986,400.00** | **156,530,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 134,986,400.00 | 156,530,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,159,514,600.00** | **1,186,759,659.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,159,514,600.00** | **1,186,759,659.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,048,766,761.54** | **1,105,814,557.45** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **795,073,724.58** | **818,806,375.13** |
| 210101 | Үндсэн цалин | 533,646,355.38 | 568,954,578.13 |
| 210102 | Нэмэгдэл | 192,231,545.20 | 178,151,175.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 69,195,824.00 | 71,700,622.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **101,300,511.96** | **106,884,853.13** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,968,369.48 | 76,456,753.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,380,191.83 | 7,607,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,700,971.68 | 6,085,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,659,054.65 | 1,521,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,591,924.32 | 15,214,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **108,928,746.00** | **131,285,983.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,628,327.00 | 5,252,889.19 |
| 210302 | Түлш, халаалт | 104,180,419.00 | 125,720,094.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 120,000.00 | 313,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,253,498.00** | **10,899,968.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 547,500.00 | 1,472,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,249,400.00 | 1,071,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,085,298.00 | 825,818.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 140,000.00 | 3,352,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 270,000.00 | 494,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,961,300.00 | 3,683,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **21,886,240.00** | **17,051,328.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,292,500.00 | 945,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,210,790.00 | 14,675,728.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,382,950.00 | 1,430,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **5,340,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 340,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 5,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **371,700.00** | 394,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 371,700.00 | 394,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,536,141.00** | **3,803,900.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,536,141.00 | 2,939,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 864,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,416,200.00** | **11,348,150.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,416,200.00 | 11,348,150.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **110,747,838.46** | **80,945,101.55** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **16,269,250.00** | **37,744,174.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,299,000.00 | 1,250,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,970,250.00 | 36,494,174.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **94,478,588.46** | **43,200,927.55** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 94,478,588.46 | 43,200,927.55 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **32,854,000.00** | **9,460,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **32,854,000.00** | **9,460,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **32,854,000.00** | **9,460,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 32,854,000.00 | **9,460,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 32,854,000.00 | 9,460,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(32,854,000.00)** | **(9,460,000.00)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,181,329,100.00** | **1,140,215,172.45** | **41,113,927.55** | **96.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,181,329,100.00** | **1,140,215,172.45** | **41,113,927.55** | **96.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,143,580,400.00** | **1,102,470,998.45** | **41,109,401.55** | **96.41** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **833,685,500.00** | **818,598,066.13** | **15,087,433.87** | **98.19** |
| 210101 | Үндсэн цалин | 582,110,600.00 | 568,746,269.13 | 13,364,330.87 | 97.70 |
| 210102 | Нэмэгдэл | 193,228,500.00 | 178,151,175.00 | 15,077,325.00 | 92.20 |
| 210103 | Урамшуулал | 58,346,400.00 | 71,700,622.00 | (13,354,222.00) | 122.89 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **112,303,600.00** | **106,884,853.13** | **5,418,746.87** | **95.17** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,875,500.00 | 76,456,753.13 | 5,418,746.87 | 93.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,607,000.00 | 7,607,000.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,085,600.00 | 6,085,600.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,521,400.00 | 1,521,400.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,214,100.00 | 15,214,100.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **151,530,900.00** | **131,285,983.19** | **20,244,916.81** | **86.64** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,127,900.00 | 5,252,889.19 | 3,875,010.81 | 57.55 |
| 210302 | Түлш, халаалт | 141,718,800.00 | 125,720,094.00 | 15,998,706.00 | 88.71 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 684,200.00 | 313,000.00 | 371,200.00 | 45.75 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,555,400.00** | **7,400,118.00** | **155,282.00** | **97.94** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,101,400.00 | 1,105,800.00 | (4,400.00) | 100.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 794,800.00 | 1,071,300.00 | (276,500.00) | 134.79 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,101,400.00 | 825,818.00 | 275,582.00 | 74.98 |
| 210404 | Ном, хэвлэл | 440,600.00 | 219,000.00 | 221,600.00 | 49.70 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 330,400.00 | 494,600.00 | (164,200.00) | 149.70 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,786,800.00 | 3,683,600.00 | 103,200.00 | 97.27 |
| **2105** | **Нормативт зардал** | 16,659,100.00 | 16,655,928.00 | **3,172.00** | **99.98** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 550,700.00 | 550,000.00 | **700.00** | **99.87** |
| 210502 | Хоол, хүнс | 14,676,500.00 | 14,675,728.00 | **772.00** | **99.99** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,431,900.00 | 1,430,200.00 | **1,700.00** | **99.88** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **13,000,000.00** | **13,000,000.00** | **-** | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,000,000.00 | 8,000,000.00 | **-** | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 | **-** | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **550,700.00** | **394,000.00** | **156,700.00** | **71.55** |
| 210702 | Дотоод албан томилолт | 550,700.00 | 394,000.00 | **156,700.00** | 71.55 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,834,400.00** | **3,803,900.00** | **30,500.00** | **99.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,970,400.00 | 2,939,900.00 | 30,500.00 | 98.97 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | 864,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,460,800.00 | 4,448,150.00 | **12,650.00** | 99.72 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,460,800.00 | 4,448,150.00 | **12,650.00** | 99.72 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **37,748,700.00** | **37,744,174.00** | **4,526.00** | **99.99** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **37,748,700.00** | **37,744,174.00** | **4,526.00** | 99.99 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,253,700.00 | 1,250,000.00 | **3,700.00** | **99.70** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,495,000.00 | 36,494,174.00 | **826.00** | **100.00** |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,181,329,100.00** | **1,140,215,172.45** | **41,113,927.55** | 96.52 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,024,798,200.00** | **1,003,929,189.26** | **20,869,010.74** | **97.96** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,024,798,200.00 | 1,003,929,189.26 | **20,869,010.74** | **97.96** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **156,530,900.00** | **136,285,983.19** | **20,244,916.81** | **87.07** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 156,530,900.00 | 136,285,983.19 | **20,244,916.81** | **87.07** |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** |
|---|---|---|
| | | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,595,250.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,595,250.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,595,250.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,499,850.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 366,850.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,133,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **395,400.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 395,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,800,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,900,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,900,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **12,595,250.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **12,595,250.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,762,250.00 |
| | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,833,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 24,524.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19,619.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Бараа материал** | 39,211.1 | 43,142.6 | 3,931.5 |
| **Үндсэн хөрөнгө** | 845,502.3 | 772,501.2 | (73,001.1) |
| **Нийт хөрөнгө** | **884,712.4** | **815,643.8** | **(69,068.6)** |
| **Өр төлбөр** | | | |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | **884,713.4** | **815,643.8** | **(69,068.6)** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **884,713.4** | **815,643.8** | **(69,068.6)** |

Бараа материалын дансны үлдэгдэл 43,142.6 мянган төгрөг болж, 3,931.5 мянган төгрөгөөр өссөн. БСУГ-аас Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд хандиваар ирсэн сургалтын хэрэглэгдэхүүний 1,723.4 мянган төгрөгөөр, ариутгалын бодис, автомаксын 169.0 мянган төгрөгөөр, ном түрээслүүлсний 3,335.8 мянган төгрөгөөр, малын нас дэвшилтийн 2,640.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн. Бараа материалын данс малын нас дэвшилтийн зарлагын 2,570.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 772,501.2 мянган төгрөг болж, 73,001.1 мянган төгрөгөөр буурсан. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан албан конторын зориулалттай тавилга эд хогшлын 4,260.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталж данснаас устгасан 20,961.4 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагджээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлогын дүн өмнөх оноос 102,011.6 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт

гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оны мөн үеэс 105,862.6 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 29,632.9 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарч нэмэгдсэн урсгал шилжүүлэг байна. Энэ нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,286,663.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,286,663.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 105,334.8 мянган төгрөгөөр бууруулж, 1,181,329.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,181,329.1 мянган төгрөгийн төсөв батлалснаас 1,024,798.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 156,530.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,024,798.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 156,530.9 мянган төгрөгийн, нийт 1,181,329.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,140,215.2 мянган төгрөгийг зарцуулж, 41,113,9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 12,595.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 12,595.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Бусад асуудлын хэсэг:**

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 772,501.2 мянган төгрөг болж, 73,001.1 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдан авсан албан конторын зориулалттай тавилга эд хогшлын 4,260.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталж данснаас устгасан 20,961.4 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагджээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 643,166.4 мянган төгрөгийн 36 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 587,116.1 мянган төгрөгийн 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын Засгийн газрын хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 43 тогтоолын хэрэгжилтийг шалгахад орон тоо бүтэц нэмээгүй боловч хөрөнгө бэлтгэж, тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,150.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд тогтоосон төлбөрийн актыг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 6,150.0 | 1 | 6,150.0 | - | - | 100.0 |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | - | - | - | - | - | - | 100.0 |
| **Нийт дүн** | **1** | **6,150.0** | **1** | **6,150.0** | **-** | **-** | **100.0** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 599,511.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 671.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8,474.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 587,116.1 мянган төгрөгийн шилэн дансны хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгөтэй холбоотой болон 3,249.8 мянган төгрөгийн МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгөв.

### 4.1 Төлбөрийн акт

*1. Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 ажилтны 1-12 сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос 345.9 мянган төгрөгийг илүү суутгасан.*

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

*2. 1 ажилтны 9-12 сарын цалингаас ХХОАТ-ыг тооцож бодоогүйгээс 325.6 мянган төгрөгийг дутуу суутгасан.*

ХХОАТ-ын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-д " Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

### 4.2 Албан шаардлага

Нийт 11 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 8,474.1 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “эрх ба үүрэг”, ”иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

**4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Монгол улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилт***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Байгууллага нь төсвийн хөрөнгөөр 3 ширхэг 3,249.8 мянган төгрөгийн өртөгтэй тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4-т энэ тогтоол батлагдахаас өмнө “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийг мөрдөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах

***2. Шилэн данстай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст 2021 онд нийт 643,166.4 мянган төгрөгийн 36 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 587,116.1 мянган төгрөгийн 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

***3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*3.1. <u>Илрүүлэлт:</u>*

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 834 ширхэг 152,261.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал: | | | | | | | | | | | |
| 1 | Засгийн газрын 43 дугаар тогтоолын холбогдох шалгуурыг хангаагүй | 1 | 3,249.8 | | | | | | | 1 | 3,249.8 |
| 2 | Цалинг буруу тооцоолон олгосон | 1 | 671.5 | | | 1 | 671.5 | | | | |
| 3 | Худалдан авалтыг Татварын цахим системд бүртгээгүй, И баримтаар баталгаажуулаагүй | 1 | 8,474.1 | | | | | 1 | 8,474.1 | | |
| 4 | Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна | 1 | - | | | | | | | 1 | - |
| **Дүн** | | **4** | **12,395.4** | **-** | **-** | **1** | **671.5** | **1** | **8,474.1** | **2** | **3,249.8** |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал: | | | | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй | 1 | 587,116.1 | | | | | | | 1 | 587,116.1 |
| **Дүн** | | **1** | **587,116.1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **587,116.1** |
| **Нийт дүн** | | **5** | **599,511.5** | **-** | **-** | **1** | **671.5** | **1** | **8,474.1** | **3** | **590,365.9** |